



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 09 өдөр

Дугаар A/653

Ховд

Ц.Сонгуульд сахилгын шийтгэл ногдуулах тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 131 дүгээр зүйлийн 131.1.2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

- Булган сумын Минжит Булган цогцолбор сургуулийн захирал Ц.Сонгууль нь Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/243 дугаар тушаалаар баталсан “Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, албан бус, насан туршийн боловсролын төвийн багш, удирдах ажилтны ёс зүйн дүрэм”-ийн 2.1.7, 3.1.4, 4.2.2, 4.2.4, 4.3.3, 4.3.4, 4.4.6 дахь заалтуудыг зөрчсөн нь аймгийн Засаг даргын 2019 оны А/357, А/546 дугаар захирамжуудаар байгуулагдсан ажлын хэсгийн дүгнэлтээр нотлогдож удаа дараа ёс зүйн зөрчил гаргаж байгаа тул албан тушаалын цалингийн хэмжээг 2 сарын хугацаагаар 20 хувиар бууруулах сахилгын шийтгэл ногдуулсугай.
- Сахилгын шийтгэлийг хэрэгжүүлж ажиллахыг тус сургуулийн нягтлан бодогчид зөвшөөрсүгэй.
- Хууль тогтоомжийг үйл ажиллагаандaa мөрдлөгө болгож, хамт олныг тэгш хүртээмжтэй удирдлагаар хангаж, ёс зүйн зөрчил гаргахгүй ажиллахыг Ц.Сонгуульд даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ

02 03236
D/Zax-A/653-Da